

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
2024 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024.06.17

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /сая.төг/	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;	-	Түгээсэн тоо (Баримтжуулсан байх)	18	19	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк болон фэйсбүүк хуудсан дээрээ байршуулсан мэдээ мэдээллийг байгууллагын фэйсбүүк хуудсанд шэйрлэж олон нийтэд суралчилсан. Тайлант хугацаанд 1 шторк, 1 мэдээлэлийг шэйрлэж олон нийтэд түгээсэн.	70
				Давтамжийн тоо (Баримтжуулсан байх)	2	2		
				Авсан хандалтын тоо (Баримтжуулсан байх)	100 гаруй	100-аас дээш		
		1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах	-	Өдөрлөг, нөлөөллийн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан тоо (Үр дүнг тооцож, баримтыг хавсаргах)	2	2	- “Нэгдье” аяны хүрээнд барилгын салбарын онцлогийг харуулсан зурагт хуудсыг боловсруулан байгууллагын пэйж хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. - Газрын харилцааны бүх төрлийн үйлчилгээ цахимжсантай холбогдуулан гарын авлагуудыг шинэчилсэн ба “Гомдол, мэдээллийг	100

							хүлээн авах утас 110” дугаарыг гарын авлага, баннер дээр байрлуулж хэвлүүлсэн. “Хариуцлагатай газрын харилцаа аян”-ы хүрээнд 8 сумын малчдын өдөрлөг, иргэдийн нийтийн хуралд нийт 1500 гаруй гарын авлага тараасан.	
		1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	-	Мэдээллийг шинэчилсэн тоо (Сар бүр шинэчилсэн нотлох баримтыг хавсаргах)	12	12	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” самбарыг байгууллагын коридорт иргэдэд ил тод байршуулсан ба мэдээллийг тогтмол шинэчилж байна. Тайлант хугацаанд дээрх самбарын мэдээллийг “Нэгдье” аяны зурагт хуудас 1, хамаарал бүхий этгээдийн судалгаа, авлигын эсрэг 2024 оны төлөвлөгөө, төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилт, хориглолт, хязгаарлалттай холбоотой мэдээлэл зэргийг байршуулж 7 удаа шинэчилсэн.	100
		1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шудрага байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим,	0,3	Сурталчилгааны материал боловсруулсан тоо	2	2	- Салбарын үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигын эрсдэлээс ангид байж, ёс зүй, шудрага байдлыг уриалсан агуулга бүхий зурагт хуудсыг боловсруулан байгууллагын фэйсбүүк, цахим хуудсуудад	100

		хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэх		Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудсанд байршуулсан тоо (Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх)	1	1	байршуулж олон нийтэд сурталчилсан. - “Нэгдье” аяны постьер, авлигыг мэдээллэх 110 дугаарыг гарын авлага дээр байршуулж, олон нийтэд сурталчилсан. - Байгууллагын фэйсбүүк хуудсанд “Иргэн таны хууль, эрх зүйн мэдлэгт” мэдээллийг 7 хоног бүр байршуулдаг ба дээрх зурагт хуудсанд мөн “Гомдол, мэдээллийг хүлээн авах утас 110” дугаарыг байршуулсан.	
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1. Төрийн байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх	-	Шинээр томилогдсон албан хаагчдыг сургалтад хамруулсан тоо	2	2	Шинээр томилогдсон албан хаагчдад АТГ-аас сургалт зохион байгуулагдаагүй болно.	ХБ
		2.2. Тус байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч	-	Нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	2	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний төслийн танилцуулах самбарыг олон нийтэд ил тод байршуулж байна. Уг самбарт захиалагч гүйцэтгэгчийн мэдээлэл, төсөвт өртөг, эхлэх дуусах хугацаа, талбайн инженер, хөдөлмөр хамгаалал хариуцсан хүний нэр, холбогдох утасны дугаар зэрэг мэдээллийг байршуулдаг. Барилга угсралтын ажил явагдаж байгаа 10 гаруй	100

		хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах					объектод шаардлага тавьж танилцуулах самбарыг байршуулаад байна.	
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.	-	Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан эсэх (тийм-1, үгүй-0)	1	1	Барилгын захиалагчийн хяналтын гэрээнд байгууллагын болон гэрээ байгуулж байгаа талын хүлээх үүрэг хэсэгт “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, авлигыг мэдээллэх, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг журмын дагуу гаргаж, бүртгүүлэх” талаар заалт тусгасан. Тайлант хугацаанд 2 гэрээ байгуулсан байна.	100
				Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх (тийм-1, үгүй-0)	1	1		
				Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	-	-		

		3.2. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх		Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх (тийм-1, үгүй-0)	-	1	Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг бие даан судалж байна. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, албан тушаалтны ёс зүй, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, энэ үйл ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах замаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгох зорилгоор байгууллагын болон албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг журмын 2.1-д заасны дагуу чиглэл байхаар тодорхойлсон. Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Засгийн газрын 2022 оны 201-р тушаалаар батлагдсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу 98 арга хэмжээнээс тус байгууллагад хамааралтай 76 арга хэмжээг QR код үүсгэн	100
				Сургалт, мэдээлэл авсан тоо	-	1		

							байгууллагын www.dundgovi.gazar.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн дээрх мэдээллийг www.shilen.gov.mn сайттай холбох ажлыг зохион байгуулаад байна.	
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м)		Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	1	1	Газрын харилцааны талаарх төрийн үйлчилгээг хүргэх, шаардлагагүй шат дамжлагыг багасгах, очер дараалал бууруулах, төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүртээмжтэй болгох зорилгоор “Газрын харилцааны цахим үйлчилгээ” хэсгийг тохижуулж, иргэдэд цахимаар үйлчилгээ авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Киоск машинаас иргэн, хуулийн этгээд газрын харилцаатай холбоотой 42 төрлийн үйлчилгээг авах боломжтой.	100
		4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцлийг арилгах арга хэмжээг зохион байгуулж ажилласан байх	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1	ГЗБГЗЗЕГ-аас АТГ-тай хамтран 2 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан ба “Олон нийтийн итгэлийг хүлээсэн авлигаас ангид нийтийн албыг бэхжүүлнэ” сэдэвт сургалтад нийт 26 албан хаагч, шинэчлэгдсэн тогтоол танилцуулах сургалтад ЭБАТ хамрагдсан.	100

				Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	1	1	Авлигаас ангид байж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх боломжит арга хэмжээг байгууллагын онцлогт тохируулан гарын авлага, мэдээллийн самбар, цахим хуудсуудад байршуулж олон нийтэдл сурталчилж байна.	
		4.3. Иргэдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	-	Бодитой үр дүнг тооцсон байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	1	1	Сэтгэл ханамжийн судалгааг 3 дугаар улиралд авахаар асуулгыг боловсруулж байна.	ХБ
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх.	5.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хүрсэн үр дүнг жилийн эцэст нийт албан хаагчдад танилцуулах.	-	Төлөвлөгөөг баталж, танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	1	1	Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг ерөнхий газар болон аймгийн ЗДТГ-аас баталсан төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж байгууллагын даргаар баталгаажуулсан. Төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас “Шудрага ёс, хөгжил дэвшилд 110” самбарт байршуулж олон нийтэд ил тод нээлттэй мэдээллэсэн.	100
				Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	1	1	Төлөвлөгөөг батлахдаа албан хаагчдын саналыг тусгах зорилгоор албан хаагчдад танилцуулахад нэмэлт санал гараагүй тул 2024 оны 1 дүгээр улиралд байгууллагын даргаар батлуулсан.	100

		5.2. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдэл, дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх.	-	Мөрдөгчийн мэдэгдэл, зөвлөмж, саналыг хэрэгжүүлсэн байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	1	1	Тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдэгдэл, зөвлөмж ирээгүй.	100
		5.3. Шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнууд НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 17 дугаар зүйлд заагдсан хандив тусламжтай холбоотой хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах.	-	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжүүлсэн байх (тийм-1, үгүй-0)	1	1	Тус байгууллагын албан хаагчид бусдаас хандив авах, хүсэх, хандивлагчтай холбоотой шийдвэр гаргах зэрэг асуудал гаргаагүй ба төрийн албан хаагчийн ёс зүйг чанд баримтлан, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг чанд баримтлан ажиллаж байна. НАНБХАСЗАСЗУС тухай хуулийн 3 дугаар бүлэг “Албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалт” сэдвээр сумдын Газрын даамлуудыг чадавхижуулах сургалтын үеэр сургалт зохион байгуулсан ба сургалтад Газрын удирдлагын хэлтсийн 18 албан хаагч бүрэн хамрагдсан.	100
		5.4. Төрийн албан хаагчдад шударга ёсыг төлөвшүүлэх зорилготой нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	-	-Төлөвлөгөө тайлантай олон нийтийг танилцуулах боломжоор хангасан байх	1	1	Тус байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оын төлөвлөгөө болон хэрэгжилтийг байгууллагын цахим хуудас болон “Шудрага ёс, хөгжил дэвшилд 110”	100

							самбарт байршуулж олон нийтэд ил тод нээлттэй мэдээллэсэн.	
		5.5. АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар пейж хуудсыг албан хаагчдаар дагуулах ажлыг зохион байгуулах.	-	Иргэдэд сурталчилж пэйжэд нэгдүүлж үр дүнг тооцсон байх (тийм-1, үгүй-0)	1	1	АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар фэйсбүүк, цахим хуудсыг албан хаагчид бүгд дагасан. Тус байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдэд болон сумдад ажиллахдаа сум, орон нутгийн иргэдэд дээрх цахим хуудсыг сурталчилж, пэйж хуудсанд нэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласан.	100
		5.6. Удирдах албан тушаалтны гаргасан шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянан үзэж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.		ХЭЗХэлтсээр хянуулсан байх, ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх (тийм-1, үгүй-0)	1	1	Тус байгууллагын даргын тушаалын төслийг Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн боловсруулж, бүртгэлийг хөтлөн хяналт тавьдаг. Тайлант хугацаанд байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбогдолтой 22 тушаал, боловсон хүчний холбогдолтой 13 тушаал албажиж гарсан. Байгууллагын даргын тушаалын хууль эрх зүйн үндэслэл, алдаа дутагдлыг жилд 2 удаа аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хянуулдаг ба 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хянуулахаар хүргүүлнэ.	100

				Дүн шинжилгээ хийсэн байх, (тийм-1, үгүй-0)	1	1	3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.	ХБ
		5.7. Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилттэй зогсонги байдалд орсон, гэрээт ажлаа гүйцэтгээгүй ажлуудын гүйцэтгэгч компани, аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээний үүргийн биелэлтийг тооцох арга хэмжээг зохион байгуулах.	-	Гэрээний үүргийн биелэлтийг тооцож, шаардлагатай тохиолдолд тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх (тийм-1, үгүй-0)	1	1	3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.	ХБ
		5.8. Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил” болгон зарласан таван “Ш” ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, гүйцэтгэлийн хувь	5 арга хэмжээ 100 хувь	5 арга хэмжээ 100 хувь	Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил” болгон зарласан таван “Ш” ажиллагааны хүрээнд төрийн захиргааны болон үйлчилгээний удирдах албан тушаалын сул орон тоо байхгүй ба томилгооны зөрчилтэй томилогдсон (Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3 дахь заалтын дагуу төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй иргэдээс томилсон) албан хаагчдын судалгааг гаргаж ТАСЗ болон ГЗБГЗЗЕГ-т тус тус хүргүүлсэн.	100

							Тус байгууллагад томилгооны зөрчил 4 байсаныг бүрэн арилгасан.	
Хугацаа болоогүй 4 арга хэмжээ Дундаж хувь 98								

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.РЭНЦЭНДОРЖ

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН (ЭБАТ)

Д.БОЛОРЧИМЭГ